

Аудит хийх үндэслэл: Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: *Төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байгаагаас уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт хангалтгүй байна.*

**”УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХӨРӨНГИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН”**



АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар	3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	БҮЛЭГ 1. Уул уурхайн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль, тогтоомжинд заасны дагуу тооцож төвлөрүүлдэггүй байна.	5
Аудитын менежер О.Амаржаргал	1.1 Уул уурхайн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хуулийн дагуу тооцож, дансанд байршуулдаггүй байна.	5
Аудитор Д.Пүрэвсүрэн Шинжээч Ч.Загдсүрэн	БҮЛЭГ 2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг сум, орон нутагт хандив маягаар үлдээж, уг мөнгийг зориулалтын бус зарцуулж байна.	7
2015 оны 11 дугаар сарын 05	2.1 Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг сум, орон нутагт хандив маягаар үлдээж, уг мөнгийг зориулалтын бус зарцуулж байна.	7
Уг тайланг АГ- ын Веб сайтаас үзнэ үү. www.tuv-audit.mn	2.2 Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлант оны байгаль орчны нөхөн сэргээлтийн талаархи мэдээ, тайлан, актыг харгалзахгүй дараа оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг батлаж байна.	9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ 3. Төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байна.	11
	3.1 АМГазар болон аймгийн БОАЖГ-ын судалгаа нь хоорондоо зөрүүтэй байгаа нь төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.	11
	3.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлт хийх ажил шаардлагын хэмжээнд хүртэл жигдрээгүй байна	12
	3.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хяналт муу, хариуцлага тооцдоггүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.	14
ХАЯГ:		16
Төв аймгийн	Дүгнэлт	17
Төрийн	Зөвлөмж	18
байгууллагын ордон	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	
	Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ	

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БОНС	Байгаль орчин нөхөн сэргээлт
БОЯ	Байгаль орчны яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
АМГ	Ашигт малтмалын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт:

Уул уурхайн нөхөн сэргээлийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд үнэлгээ, дүгнэлт өгч дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулна. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд :

- Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх
- Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх
- Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад 2013-2014 онд “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн биелэлтийг хариуцсан төрийн байгууллагуудын /аймгийн МХЕГ, аймгийн ЗДТГ ба бусад/ тайлант жилүүдэд хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт материал, хөндлөнгийн хараат бус байгууллагын судалгаа, шинжилгээний дүгнэлтийг ашиглав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хамрах хүрээ, арга хэлбэр, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлт, шилдэг практик, арга туршлагатай харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол улсын үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
- Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой стандартууд
- MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт
- MNS5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн аудитын газрын менежер О.Амаржаргал удирдаж, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар 2015 оны 8 дугаар сарын 20-ноос эхлүүлж, 11 дугаар сарын 5-ны өдөр нэгтгэлийн багт хүргүүллээ.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль
тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх

Бүлэг 1

Уул уурхайн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа
хөрөнгийг хууль, тогтоомжинд заасны дагуу тооцож төвлөрүүлдэггүй
байна.

1.1 Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож төлөвлөж байна уу?

Уул уурхайн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг
хуулийн дагуу тооцож, дансанд байршуулдаггүй байна.

Төв аймаг нь нийт 7404.2 мянган га талбайг хамарсан газар нутагтай бөгөөд 2013 онд нийт 545.9 мянган га газрыг хамарсан 413 тусгай зөвшөөрөл олгогдсоны 69.9 мянган га газрыг хамарсан 238 ашиглалт, 476.1 мянган га газрыг хамарсан 175 хайгуулын тусгай зөвшөөрөл байна. 2014 онд 370.1 га газрыг хамарсан 409 тусгай зөвшөөрлийн 109.5 га-г хамарсан 273 ашиглалтын, 260.6 га-г хамарсан 136 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

	2013 он	2014 он
Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч	413	409
Талбайн хэмжээ га	545.9	370.1
Үүнээс: Ашиглалт	238	273
Талбайн хэмжээ га	69.6	109.5
Хайгуул	175	136
Талбайн хэмжээ га	476.1	260.6

Тусгай зөвшөөрөл олгогдсон газрын хэмжээ нь 2014 оны байдлаар аймгийн нийт газар нутгийн 5 хувийг эзэлж байна.

2014 онд нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайн хэмжээ 175.8 га талбайгаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо 4-өөр буурсан бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо 39, талбайн хэмжээ 215.5 га буурч, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо 35-аар, талбайн хэмжээ 39.9 га-гаар нэмэгдсэн байна.

“Ашигт малтмалын тухай хууль”-ийн 38, 39 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.9, 9.10-т тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээх үүргээ биелүүлэхийн баталгаа болгон мөнгөн хөрөнгө байршуулах тухай зааж өгсөн байна. Тус хуулиар ашиглах, баяжуулах, боловсруулах, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн байгалийн нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн 50 хувийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 38.1.8-д заасны дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын 50 хувийг орон нутагт байршуулж байна.

2013 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 23 аж ахуйн нэгж байгууллагын 137.2 сая төгрөг, 2014 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 19 аж ахуйн нэгж байгууллагын 155.7 сая төгрөг Төрийн захиргааны төв байгууллагын дансанд төвлөрсөн байна.

Уул уурхайн нөхөн сэргээлт, барьцаа хөрөнгийн зарцуулалт, үр дүнг ҮАГ болон аймгийн аудитын газрын аудитор нар Заамар суманд шалгалаа. Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын 6 тусгай зөвшөөрөл эзэмшигч, мөн Алтан дорнод монгол ХХК-ий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа явуулж буй 9, нийт 15 аж ахуйн нэгж шалгалтад хамрагдлаа. Шалгалтаар дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Монголросцветмет нэгдлийн Зэрэгцээ алтны уурхай нь 2007 онд 15.0 сая төгрөг байршуулсан, 2013 онд БОНС-ийн зардалд 648.2 сая төгрөг төлөвлөж 8.5 сая төгрөг, 2014 онд 482.0 сая төгрөг төлөвлөсөн боловч барьцаа хөрөнгө байршуулаагүй, нийт дүнгээрээ 26.4 сая төгрөг байршуулсан,

- Монполимет ХХК нь БОНС зардалд 304.8 сая төгрөг төлөвлөсөн боловч барьцаа хөрөнгө байршуулаагүй

- 2014 онд Мондулаан трейд ХХК нь барьцаа хөрөнгө байршуулаагүй,

- Тод ундарга ХХК нь 2013, 2014 онуудад батлагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө байхгүй үйл ажиллагаа явуулж байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь байгаль хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээлтэд зарцуулах зардлаа АМГ-аар батлуулж, барьцаа хөрөнгөө дансанд байршуулдаггүй болох нь Заамар суманд газар дээр нь очиж хийсэн шалгалтаар харагдаж байна. Бусад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагт байгаль хамгаалах төлөвлөгөө, зардлаа батлуулдаггүй учир нөхөн сэргээлтийн барьцаанд хэдийг байршуулахаас хэдэн төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулсан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

2013 онд шалгалтанд хамрагдсан хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 59 аж ахуйн нэгжээс орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 37 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 33.1 сая төгрөгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулж, 16.7 сая төгрөг барьцаа дансанд байршуулахаас, 28.8 сая төгрөг байршуулсан байна.

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулсан 37 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс:

- 11 тусгай зөвшөөрөл эзэмшигч 18.2 сая төгрөгийн төлөвлөгөө батлуулж, 9.1 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулан, үйл ажиллагаа явуулж, нөхөн сэргээлтээ актаар хүлээлгэж өгсөн

- 17 компани 9.6 сая төгрөгийн байгаль хамгаалах төлөвлөгөөгөө батлуулж, 4.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулсан, актаар хүлээлгэж өгөөгүй,

- 6 тусгай зөвшөөрөл эзэмшигч 4.6 сая төгрөгийн БОНС зардлын төлөвлөгөө батлуулж, 2.3 сая төгрөг барьцаа хөрөнгөөр байршуулах байсан боловч барьцаа хөрөнгө байршуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй

- 1 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулж, 0.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй байна.

- Төлөвлөгөөнөөс дутуу байршуулсан 3 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 0.4 сая төгрөг байна.

Мөн 22 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулаагүй, 12.1 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаанд байршуулсан байна.

2014 онд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 39 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа 26.4 сая төгрөгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулж, 13.2 сая төгрөг байршуулахаас 18.1 сая төгрөг байршуулсан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулсан 39 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс:

- 5 тусгай зөвшөөрөл эзэмшигч 13.2 сая төгрөгийн төлөвлөгөө батлуулж, 6.6 сая төгрөг байршуулахаас 6.9 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулан, үйл ажиллагаа явуулж, нөхөн сэргээлтээ актаар хүлээлгэж өгсөн
- 14 компани 4.4 сая төгрөгийн байгаль хамгаалах төлөвлөгөөгөө батлуулж, 2.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулсан, актаар хүлээлгэж өгөөгүй,
- 14 тусгай зөвшөөрөл эзэмшигч 7.4 сая төгрөгийн БОНС зардлын төлөвлөгөө батлуулсан боловч барьцаа хөрөнгө 3.7 сая төгрөгийг байршуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй,
- 4 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулж, 1.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгөө байршуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй,

Мөн 12 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулаагүй, 7.1 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаанд байршуулсан.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, зардал батлуулдаг боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээх үүргээ биелүүлэхийн баталгаа болгон байршуулах мөнгөн хөрөнгийг байршуулдаггүй, мөн мөнгөн хөрөнгө байршуулаагүй тохиолдолд “Ашигт малтмалын тухай” хуулийн 39.6-д заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй гэсэн хуулийн заалтууд хэрэгждэггүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хууль, журмын дагуу зарцуулсан уу?

Бүлэг 2

Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг сум, орон нутагт хандив маягаар үлдээж, уг мөнгийг зориулалтын бус зарцуулж байна.

2.1 Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулж байна уу?

Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг сум, орон нутагт хандив маягаар үлдээж, уг мөнгийг зориулалтын бус зарцуулж байна.

2013 онд 17 сумын Төрийн санд байрших Байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа сангийн данс нь 87.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй, нийт 49.1 сая төгрөгийн орлого төвлөрч, 23.7 сая төгрөг зарцуулагдаж, оны эцэст 113.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус дансанд 43 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 26.3 сая төгрөг, мөн 7.2 сая төгрөгийн санхүүжилт, 15.6 сая төгрөгийн бусад орлого төвлөрчээ. Тус барьцаа сангаас 23.7 сая төгрөг зарцуулагдсны 4.9 сая төгрөг нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө, үлдсэн 18.8 сая төгрөг нь бусад зардал байна.

Аудитын явцад орон нутгийн БОНС-н зардалын төвлөрүүлэлт, зарцуулалттай холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

-Заамар сум нь 10 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхөн сэргээлтийн барьцаа 2.5 сая төгрөгийг байгаль хамгаалах санд байршуулсан

-Байгаль хамгаалах сангийн хөрөнгөнөөс Бүрэн сум 6.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 5.9 сая төгрөг, Өндөрширээт сум 10.6 сая төгрөгийг төвлөрүүлж, 6.0 сая төгрөг зарцуулсан,

-Борнуур сумын барьцааны дансанд мал хамгаалах сангийн 2.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 3.2 сая төгрөгийг Зуунмод улсын нөөцийн салбарт өвсний үнэнд шилжүүлж, 0.3 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, мөн сумын ОНТ-т 1.6 сая төгрөгийн актыг барагдуулсан,

-Эрдэнэсант сумын төсвийн байгууллагуудын усны төлбөрт төвлөрсөн нийт 1.4 сая төгрөгийг уг барьцаа дансанд төвлөрүүлж, зарцуулсан нь "Төсвийн тухай" хуулийн 23.8-д "сум, дүүргийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ. Үүнд: "Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2013 онд зарим аж ахуйн нэгж байршуулсан барьцаа мөнгөө буцаан авах албан тоот ирүүлжээ.

Бүрэн суманд хайгуулын үйл ажиллагаа явуулсан Би ар икс ХХК 1.3 сая төгрөг, СТЛТ ХХК 0.6 сая төгрөгийн барьцаа мөнгийг буцаан олгохдоо нөхөн сэргээлтийг хүлээн авсан тухай акт үйлдэлгүй, тухайн аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан тоотыг сумын Засаг дарга цохож, 1.9 сая төгрөгийг дээрх 2 аж ахуйн нэгжид олгожээ.

Баянцогт суманд хайгуулын үйл ажиллагаа явуулсан "Сонин хад" ХХК нь 2013 онд 6.5 сая төгрөгийг сумын цэцэрлэгжүүлэлт, тохижилтод зарцуулахыг зөвшөөрсөн албан тоот ирүүлж тухайн жилд сум 3.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус аж ахуйн нэгж нь сумын тохижилт, цэцэрлэгжүүлэлтэд зарцуулах хүсэлт гаргасан боловч зарцуулахдаа 0.9 сая төгрөгийг үзэсгэлэн худалдааны зардалд, 0.3 сая төгрөгийг согтолт хэмжих багаж авсан, 0.2 сая төгрөгийн актын төлбөр зэргээр өөр зүйлд зарцуулжээ.

2014 онд Төв аймгийн 17 сумын Төрийн санд байрших Байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа сангийн тусгай данс нь 113.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй, 44.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 22.9 сая төгрөг зарцуулагдаж, оны эцэст 135.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус дансанд 32 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 37.1 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа, 7.8 сая төгрөгийн бусад орлого төвлөрчээ.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа сангийн төвлөрүүлэлттэй холбоотой илэрсэн асуудлуудаас дурьдвал:

-Заамар сум нь 13 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 1.6 сая төгрөгийг байгаль хамгаалах сангийн дансанд төвлөрүүлсэн

-Бүрэн сумын барьцаа хөрөнгийн дансанд 2.6 сая төгрөгийн санхүүжилт, 2.2 сая төгрөгийн орлого, нийт 4.8 сая төгрөгийн өөр эх үүсвэр төвлөрүүлсэн,

-Эрдэнэсант сумын төсвийн байгууллагуудын усны төлбөр 1.2 сая төгрөгийн орлогыг байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа санд төвлөрүүлсэн байна.

Тус барьцаа данснаас 22.9 сая төгрөг зарцуулагдсны 5.6 сая төгрөг нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө бөгөөд 3.3 сая төгрөг нь өмнөх оны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө буцаалтын үлдэгдэл, үлдсэн 17.3 сая төгрөг нь бусад зардал байна.

2014 онд 4 аж ахуйн нэгж 2.3 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг буцаан авах албан тоотоо ирүүлжээ. Үүнд: Баян сумын нэг аж ахуйн нэгж 0.3 сая төгрөг, Баяннөнжүүл сумын 2 аж ахуйн нэгж 1.6 сая төгрөг, Бүрэн сумын 1 аж ахуйн нэгж 0.5 сая төгрөгийн барьцаа мөнгийг буцаан авахаар хүсэлтээ ирүүлж, Баяннөнжүүл сумын 2 аж ахуйн нэгжийн 1.6 сая төгрөгийг /Легенд майнз 0.6 сая төгрөг, Эрдэнэжас ХХК 1.0 сая төгрөг, нийт 1.6 сая төгрөг/

суманд нь өгөх хүсэлт хүргүүлсний дагуу сумын байгаль хамгаалах санд шилжүүлсэн байна.

-Тус дансанд байгаль хамгаалах сангийн орлогыг төвлөрүүлж, Бүрэн сум 4.6 сая төгрөг, Өндөрширээт сум 6.6 сая төгрөгийг зарцуулсан,

-Алтанбулаг сум нь хогийн цэгийн тохижилтод 3.0 сая төгрөг,

-Дэлгэрхаан сумын Засаг даргын гадаад томилолтын зардалд 1.6 сая төгрөгийг зарцуулж, сумын ЗДТГ-аас буцааж шилжүүлсэн,

Орон нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулсан зарим аж ахуйн нэгжүүд байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг сум, орон нутагт нь үлдээж, хандив маягаар өгдөг байна. Энэ мөнгийг сум орон нутаг хэрхэн зарцуулах, юунд зарцуулах нь эрх зүйн хувьд тодорхой зохицуулалтгүй явж ирсэн байна.


Зарим тохиолдолд сум орон нутагт байгаль орчныг нөхөн сэргээж хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй байхад зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн албан тооцоор буцаан олгосон байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг хуульд заасны дагуу буюу байгаль хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулсан тохиолдол Төв аймагт 2013 оноос хойш гараагүй байна.

2.2 Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлант оны байгаль орчны нөхөн сэргээлтийн талаархи мэдээ, тайлан, актыг харгалзахгүй дараа оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг батлаж байна.

Аймгийн БОАЖГ-ын гаргасан судалгаагаар аймгийн хэмжээнд 40 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 40 уурхай тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уул уурхайн зориулалтаар 5.8 мянган га газар хөндөгдсөн нь аймгийн нийт газар нутгийн 0.08 хувийг эзэлж байна. 2007 оноос хойш гаргасан мэдээгээр нийт 4.6 мянган га-д нөхөн сэргээлт хийгдсний 2.7 мянган га-д техникийн, 1.8 мянган га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. Аймгийн газрын алба нь 2013 онд нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон газрын судалгааг гаргасан бөгөөд уг судалгаагаар уул уурхайн зориулалтаар хөндөгдөөд нөхөн сэргээлт хийгдээгүй эзэнгүй, орхигдсон газрын хэмжээ 0.16 мянган га газар байна. Үүнд: Баян суманд 37.44 га, Заамар суманд 121.5 га, Мөнгөнморьт суманд 1.2 га, Сүмбэр суманд 0.29 га газар байна.



АМГ-аас ирүүлсэн 2013 оны судалгаанд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 19 аж ахуйн нэгж байгууллага нийт 191.16 га талбайг уулын ажилд хамруулж, 320.134 га талбайд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсний 185.34 га талбай техникийн, 135 га талбай биологийн нөхөн сэргээлтэд хамрагдахаар байна. Гүйцэтгэлээр 473.1 га талбайд нөхөн сэргээлт хийснээс 273.59 га-д техникийн, 199.51 га талбай биологийн нөхөн сэргээлтэд хамрагджээ. 2013 онд уулын ажилд хамрагдахаар төлөвлөсөн талбайгаас 281.94 га газар, нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбайгаас 152.97 га талбайд илүү нөхөн сэргээлт хийсэн байна.

Аймгийн БОАЖГазар нь 2013 онд 22 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхөн сэргээлт хийсэн нийт 1042.633 га талбайг хүлээн авч акт үйлдсний 394.273 га талбай нь биологийн, 648.36 га нь талбай нь техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай байна.

Ашигт малтмалын газар болон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь хоорондоо 569.53 га-гаар зөрүүтэй, аймаг, орон нутаг актаар хүлээж аваагүй зарим аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг ашигт малтмалын газрын судалгаагаар гарсан, мөн нөхөн сэргээлт хийж орон нутагт актаар хүлээлгэж өгсөн боловч ашигт малтмалын газрын гаргасан мэдээ, судалгаанд байхгүй зэрэг тоон мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байна.

АМГ-аас ирүүлсэн 2014 оны судалгаанд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 22 аж ахуйн нэгж, байгууллага нийт 241.33 га талбайг уулын ажилд хамруулж, 330.49 га талбайд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсний 200.54 га талбай техникийн, 129.95 га талбай биологийн нөхөн сэргээлтэд хамрагдахаар байна. Гүйцэтгэлээр 380.39 га талбайд нөхөн сэргээлт хийснээс 227.3 га-д техникийн, 153.09 га талбай биологийн нөхөн сэргээлтэд хамрагджээ. 2014 онд уулын ажилд хамрагдахаар төлөвлөсөн талбайгаас 139.06 га газар, нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбайгаас 49.9 га талбайд илүү нөхөн сэргээлт хийсэн байна.

Аймгийн БОАЖГазар нь 2014 онд 25 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхөн сэргээлт хийсэн нийт 554.47 га талбайг хүлээн авч акт үйлдсний 311.94 га талбай нь биологийн, 242.53 га талбай нь техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай байна.

АМГ болон аймгийн БОАЖГ-ын нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь хоорондоо 174.08 га-гаар зөрүүтэй, аймаг, орон нутаг актаар хүлээж аваагүй, зарим аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ ашигт малтмалын газрын

судалгаагаар гарсан, мөн нөхөн сэргээлт хийж орон нутагт актаар хүлээлгэж өгсөн боловч ашигт малтмалын газрын гаргасан мэдээ, судалгаанд байхгүй зэрэг тоон мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байна.

Аудитын явцад Заамар суманд ажиллахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

-Тод ундарга ХХК нь 2013, 2014 онуудад батлагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө байхгүй, 2014 онд байгаль орчны нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй,

Мөн нөхөн сэргээлт хийж хүлээн авсан акт дээр сав газрын захиргаа, нөлөөллийн бүсийн иргэдийн төлөөллийн гарын үсэг зурагдаагүй зэрэг зөрчлүүд байна.



Нөхөн сэргээлт хийгдсэн талбай



Орхигдсон газар

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг тооцоход АМГазар болон аймгийн БОАЖГ-аас гаргаж ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээ, тайлан, акт, баримт материал нь хоорондоо зөрүүтэй байна.

Судалгаанаас харахад АМГазар нь зарим аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлтийг аймаг, орон нутаг актаар хүлээж аваагүй байхад нөхөн сэргээлт хийсэн гэж тоо, мэдээндээ оруулж дараа жилд олборлолт явуулах боломжийг бүрдүүлж байна

Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх

Бүлэг 3

Төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байна.

3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, тайлан, мэдээг хуульд заасан хугацаанд хүлээн авч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна уу?

АМГазар болон аймгийн БОАЖГ-ын судалгаа нь хоорондоо зөрүүтэй байгаа нь төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

АМГ-аас ирүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн судалгаанд 2013 онд 58 аж ахуйн нэгжээс 29 нь уулын ажлын төлөвлөгөө ирүүлснээс 19 нь байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын тайлангаа гаргаж ирүүлсэн, 2014 онд 58 аж ахуйн нэгжээс 24 нь уулын ажлын төлөвлөгөө ирүүлснээс 22 нь байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын тайлангаа гаргаж ирүүлсэн байна.

АМГ-аас ирүүлсэн мэдээгээр 2013 онд 157 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 103 нь хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 59 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 37 нь үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа 16.5 сая төгрөгийн байгаль хамгаалах хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулж, 8 компани 8.2 сая төгрөгийн байгаль хамгааах, нөхөн сэргээлт хийсэн ажлын тайланг ирүүлж, актаар хүлээлгэж өгсөн байна.

Аудитын явцад дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

-17 компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө батлуулж, барьцаа хөрөнгө байршуулан, үйл ажиллагаа явуулсан боловч нөхөн сэргээлтээ хийж, орон нутагт талбайгаа хүлээлгэн өгөөгүй. Үүнд Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй хайгуулын 11 тусгай зөвшөөрөл дээр үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд нь талбайгаа актаар өгөөгүй,

- 6 тусгай зөвшөөрөл эзэмшигч 2.3 сая төгрөгийн БОНС зардлын төлөвлөгөө батлуулсан боловч барьцаа хөрөнгө байршуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй

-20 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулаагүй, 7.7 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаанд байршуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй

-2 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулж, 0.4 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй

АМГ-аас ирүүлсэн мэдээгээр 2014 онд 136 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 60 нь хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 53 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 39 нь үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа 13.2 сая төгрөгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө батлуулж, 18.1 сая төгрөг байршуулан, 6 компани 7.1 сая төгрөгийн

байгаль хамгаалах, нөхөн сэргээлт хийсэн ажлын тайланг ирүүлж, актаар хүлээлгэж өгсөн байна. Аудитын явцад дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 14 компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө батлуулж, барьцаа хөрөнгө байршуулан, үйл ажиллагаа явуулсан боловч нөхөн сэргээлтээ хийж, орон нутагт талбайгаа хүлээлгэн өгөөгүй байна. Үүнээс 11 тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Заамар суманд үйл ажиллагаа явуулсан байна.

- 14 тусгай зөвшөөрөл эзэмшигч 3.7 сая төгрөгийн БОНС зардлын төлөвлөгөө батлуулсан боловч барьцаа хөрөнгө байршуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй

- 4 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулж, 1.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгөө байршуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй

- 10 компани байгаль хамгаалах төлөвлөгөө батлуулаагүй, 3.8 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаанд байршуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй байна.

АМГазар болон аймгийн БОАЖГ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, мэдээний талаархи 2 жилийн судалгаанууд нь хоорондоо зөрүүтэй байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөвлөгөө, тайлан мэдээ буруу гардаг, түүнд тавих хяналт байдаггүйгээс хариуцлага тооцогддоггүй, төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь мэргэжлийн байгууллагын ажлын уялдаа холбоо байхгүйг харуулж байна.

Энэ нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 39.1.5, 39.1.7-д заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ, хуулбар хувийг аймаг, сум орон нутагт хүргүүлнэ гэсэн заалт хэрэгжихгүй байна.

3.2 Бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажил үр нөлөөтэй байна уу?

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлт хийх ажил шаардлагын хэмжээнд хүртэл жигдрээгүй байна

Аймгийн хэмжээнд Засгийн газрын 2010 оны 308-р тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу Заамар, Сэргэлэн сумдад 2013-2015 онуудад иргэд Нөхөрлөлийн хэлбэрт шилжин бичил уурхайн олборлолт явуулахаар сум орон нутгийн төрийн байгууллагатай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулсан байна.

Сэргэлэн суманд 2013 онд Цэлгэр нуур, Цагд-Уул, Андууд, Баялагхангай зэрэг нөхөрлөлүүд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулахаар сумын Засаг даргатай гэрээ байгуулсан боловч эдгээр нөхөрлөлүүд нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу үйл ажиллагаа явуулаагүй тул сумын засаг дарга байгуулсан гэрээгээ цуцалсан байна. 2014-2015 онд тус суманд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу Засаг даргатай гэрээ байгуулан ажилласан нөхөрлөл байхгүй байна.

Заамар суманд 2013 онд “Алтандорнод”, “Мондулаан” ХХК-ний ашигт малтмал олборлон ашигласан шорооны улан дээр 8 нөхөрлөл дахин олборлох үйл ажиллагаа явуулж нөхөн сэргээлтийн асуудлыг дээрх хоёр аж ахуйн нэгж бүрэн хариуцан хийсэн гэж тайлагнасан байна.

Тус суманд 2014 онд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан Төмстэй багийн нутаг “Цагаанчулуут”-д 24,5 га газарт ЗаамарХаан ХХК, Галданбуянт ХХК-иудтай гурвалсан гэрээгээр 8 нөхөрлөлийн 192 бичил уурхайн нөхөрлөлийн гишүүд ашигт малтмал олборлолт явуулж нөхөн сэргээлт хийлгэсэн байна. Үүний 24,5 га газарт техникийн нөхөн сэргээлт, 4,5 га газарт биологийн нөхөн сэргээлтийг дээрх хоёр аж ахуйн нэгжээр хийлгүүлж сумын ИТХ-ын 2014 оны 12-р сарын 17-ны 07-р тогтоолоор нөхөн сэргээлт хийсэн талбайг 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын

хэсгийн шалгасан дүгнэлтийг үндэслэн сумын тусгай хэрэгцээнд буцааж хүлээн авсан байна.

Мөн Ашигт малтмалын хэрэг эрхлэх гарын зөвшөөрөл дүгнэлттэй 17,85 га талбайд 3 нөхөрлөл ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулснаас ганцхан “Бүрд” нөхөрлөл үйл ажиллагаа явуулсан байна.

2015 онд Заамар сумын ИТХ-ын 2015 оны 3-р сарын 30-ны өдрийн “Бичил уурхайн хэлбэрээр ашиглах газрыг сумын тусгай хэрэгцээнд авах” тухай 07-р тогтоолын дагуу сумын Засаг дарга 2015 онд иргэдээс бичил уурхайгаар ашиглах хүсэлт гаргасан нэр бүхий 30 координатын цэгийг ашиглуулахаар Ашигт малтмалын газарт уламжлан, хариу зөвшөөрөл дүгнэлт ирүүлсэн 41,89 га газарт бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоор хавсралт нэр бүхий 21 нөхөрлөлтэй гэрээ байгуулсан байна. Эдгээр гэрээ байгуулсан 21 нөхөрлөлөөс 6 нөхөрлөл тогтмол үйл ажиллагаа явуулж, бусад 15 нөхөрлөл хөрөнгө, мөнгө, санхүү, техник хэрэгслийн дутагдалтай, өгөгдсөн талбайд ашиглах нөөц байхгүй зэрэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна. Эдгээр үйл ажиллагаа явуулсан нөхөрлөлүүдийн гэрээгээр ашигласан талбайн нөхөн сэргээлтийг 2015 оны 11-р сард эрх бүхий байгууллагын томилогдсон комисс, байгаль орчны улсын байцаагч нар шалгаж хүлээж авах юм байна.

Бичил уурхайгаар ашиглалт явуулсан нөхөрлөлүүд Засгийн газрын 2010 оны 308-р тогтоолоор баталсан журмын 10-р зүйлийн 10.2, 10.3-т заасны дагуу нөхөрлөл болон нутгийн захиргааны байгууллага нь нөхөн сэргээлтийн дундын санг байгуулаагүй, ашигласан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зааврын дагуу хийж байгаль орчны улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан сумын Засаг даргын томилсон комисст хүлээлгэн өгсөн акт баримт байхгүй байна.

Дээрх журмын 11-р зүйлийн 11.1.10-т Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд 500 см³-ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизм ашиглахыг хориглох заалт бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна.

Өнөөдрийн байдлаар тус суманд уул уурхайн олборлолт явуулаад нөхөн сэргээлт хийгдээгүй зарим аж ахуйн нэгжүүдийн орхигдсон талбайнууд, мөн хувиараа ашигт малтмал олборлогч иргэд “нинжа” нарын зөвшөөрөлгүй ухаж цооног гарган сэндийчсэн нөхөн сэргээлт хийгээгүй орхигдсон 135,7 га талбай байна.

Аймгийн хэмжээнд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны улмаас хөндөгдөж ашиглагдаад нөхөн сэргээлт хийгдээгүй он удаан жил болсон, мөн хувиараа ашигт малтмал олборлох иргэдийн үйл ажиллагаанд хөндөгдөн эвдэгдэж, орхигдсон талбайг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар дахин хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж нөхөн сэргээлт хийлгэх зайлшгүй шаардлагатай байна.

3.3 Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ хэрэгжүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож байна уу?

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хяналт муу, хариуцлага тооцдоггүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2013 онд аймгийн мэргэжлийн хяналт газраас байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтээр Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хийсэн шалгалтаар 4 аж ахуйн нэгжид зөрчил илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Шалгалтаар дараахь зөрчлүүд илэрсэн байна.

-Монгол росцветмет нэгдлийн Зэрэгцээ алтны уурхай нь төлөвлөгөөнд тусгагдаагүй талбайд ашиглалт явуулсан, шимт хөрсийг стандартын дагуу хадгалж хамгаалаагүй, хөрс ус агаарын шинжилгээ өгөөгүй, уурхайн хажуугийн доголын өнцөг зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй зэрэг зөрчил илэрсэнд үйл ажиллагааг түр зогсоож, 1 сая төгрөгийн шийтгэвэр ноогдуулан, үйл ажиллагааг түр зогсоож, зөрчлийг арилгасан

-Асгат эрдэнэ ХХК нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгөөгүй байсан тул үйл ажиллагааг зогсоосон

-Жотойбажууна ХХК хөрс, ус, агаарын шинжилгээ өгөөгүй байсанд хугацаатай үүрэг өгч зөрчлийг арилгуулсан

-Уулс Заамар ХХК шимт хөрсийг стандартын дагуу хадгалаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийгээгүй байсанд 1 сая төгрөгийн шийтгэвэр ноогдуулан, үйл ажиллагааг түр зогсоож, зөрчлийг арилгасан байна.

2014 онд хийсэн шалгалтаар Заамар, Сэргэлэн, Баянцагаан сумдад үйл ажиллагаа явуулж буй нийт 11 аж ахуйн нэгжид зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага өгч, зөрчлийг арилгуулсан байна. Эдгээр 11 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 10 нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй байсан байна.

Аудитын явцад дараахь зөрчлүүд илэрлээ.

-Сэргэлэн, Бүрэн сумдын байцаагч нар байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг байршуулахгүйгээр төлөвлөгөөг батлаж, нөхөн сэргээлт хийсэн талбайг актаар хүлээж авдаггүй, тухайн компаний хайгуулын ажлын тайланг тамга дарж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

-Сэргэлэн сум нь 2013, 2014 онд байгаль хамгаалах төлөвлөгөө болон нөхөн сэргээлтийг хүлээж авсан акт байхгүй. Тус суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд нь хайгуулын ажил хийх төлөвлөгөө батлуулсан боловч сум, орон нутгаар байгаль орчны төлөвлөгөө батлуулаагүй, байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг байршуулаагүй байна. Үүнд: “Нийслэл өргөө” ХК-ий “Долоон” нэртэй хайгуулын 12139х тусгай зөвшөөрлөөр 300.0 мянган төгрөг, Цэвдэг ХХК-ий 315.0 мянган төгрөг, “Бурхан халдун групп” ХХК 215.0 мянган төгрөг, “Цогт онон” ХХК 65.0 мянган төгрөг байна.

-Баян сумын 13795Х хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Эрдэнийн цахирмаа” ХХК 2013 онд байгаль орчны төлөвлөгөө батлуулаагүй, дансанд барьцаа хөрөнгийг байршуулаагүй байхад байгаль орчны улсын байцаагч байгаль орчны нөхөн сэргээх төлөвлөгөө батлуулж, дансанд барьцаа хөрөнгийг байршуулсан тухай дүгнэлтийг гаргасан байна.

-Мөн 10715Х, 7715Х, 9237Х, 9884Х тусгай зөвшөөрөлтэй Пибоди винсэй ресорс ХХК 2009-2013 онд 4.8 сая төгрөг байршуулсан бөгөөд уг мөнгийг буцаан авах тухай албан тоот ирүүлжээ. Тус байгууллагаас ирүүлсэн жагсаалтад 2013 онд 400.0 мянган төгрөг байршуулсан гэсэн боловч уг мөнгө барьцаа дансны хуулгаар байхгүй байна. Уг мөнгийг шийдвэрлэхийг сумын Засаг дарга цохсон боловч, шилжүүлээгүй байна.

“Ашигт малтмалын тухай” хуулийн 11.3-т заасны дагуу уг хуулийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэж байгаа бөгөөд сум, орон нутагт ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байцаагч нар нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих хяналтын ажлыг хангалтгүй хийдэг, зарим улсын хяналтын байцаагч нар нь хуулийн мэдлэг дутуугаас ажлаа хийж мэддэггүй зэрэг зөрчил, дутагдал байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу тооцож, байршуулдаггүй байна.
2. Орон нутагт төвлөрүүлж буй хайгуулын тусгай зөвшөөрлийн байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг аж ахуйн нэгжүүд буцааж авдаггүй зарим тохиолдолд албан тоот хүргүүлж тухайн орон нутагт хандивлаж байгаа нь эрх зүйн хувьд зохицуулалтгүй орхигдож, уг мөнгийг дур зоригороо зарцуулах боломжийг бүрдүүлж байна.
3. Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг хуульд заасны дагуу буюу байгаль хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулсан тохиолдол Төв аймагт 2013 оноос хойш гараагүй байна.
4. АМГазар болон аймгийн БОАЖГ-ын нөхөн сэргээлтийн талаархи мэдээ, судалгаанууд нь хоорондоо зөрүүтэй байгаагаас улсын хэмжээний нөхөн сэргээлтийн мэдээлэл бодит бус байна.
5. Төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь мэргэжлийн байгууллагын ажлын уялдаа холбоо муу байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тооцох хариуцлага байхгүй байна.
6. Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ашиглаад нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдон он удаан жил болсон, мөн хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хөндөгдөн, орхигдсон талбайг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар дахин хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж нөхөн сэргээлт хийлгэх зайлшгүй шаардлагатай байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн БОАЖГазрын дарга Ж.Батцэнгэл, МХГ-ын дарга Т.Мөнхсүлд, сумдын Засаг дарга нарт зөвлөх нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн барьцаа хөрөнгийг хуулийн дагуу тооцож төвлөрүүлэх, төвлөрүүлээгүй тохиолдолд дараа жилийн олборолтын ажлыг эхлүүлэхгүй байх ажлыг зохион байгуулах, буцаан олголтыг хууль, журамд заасны дагуу жил бүр хийх

2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нөхөн сэргээлтийн ажлаа гүйцэтгээд барьцаа хөрөнгөө сум орон нутагт үлдээж байгаа тохиолдолд тус мөнгийг байгаль хамгаалах санд төврөлүүлэхээр зохицуулалтыг хийх хууль эрх зүйн орчин бүрдүүлэх талаар холбогдох дээд байгууллага, аймгийн ИТХуралд санал оруулж шийдвэрлүүлэх

3.Төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулах

4. Хуулийн дагуу нөхөн сэргээлт хийгээгүй, тайлан мэдээ буруу гаргасан албан тушаалтан, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хариуцлага тооцох

5. 2010 оноос өмнө уул уурхайн олборлолт, ашиглалт явуулаад нөхөн сэргээлт хийгээгүй орхигдсон ашиглалт явуулсан аж ахуйн нэгжүүд нь олдохгүй байгаа томоохон овоолго шороо, нүхнүүд болон мөн хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн /нинжа нарын/ зөвшөөрөлгүй ухаж сэндийчиж орхисон нүх, цооногийг улс, аймаг, сумдын хэмжээнд нэгдсэн үзлэг тооллого хийж дүнг нэгтгэн гаргаж, хөрөнгийн асуудал, нөхөн сэргээлт хийх ажлыг БОХНХөгжлийн яаманд хандан шийдвэрлүүлэх.

Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ

Холбогдох байгууллагын санал



ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг

Утас: 70273290, Факс: 70272457

E-mail: boajg_tuv@yahoo.com Цахим хуудас: baigali.to.gov.mn

2015.11.09 № 07/532

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагын 2013, 2014 оны “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд аудитын шалгалт хийсэн дүгнэлтийг зөвшөөрч байна.

Цаашид аудитын газраас өгсөн зөвлөмжийг ажилдаа хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГА



Ж.БАТЦЭНГЭЛ